



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2013 оны 06 сарын 27 өдөр

Дугаар 222

Улаанбаатар хот

Г “Чинду” ХЗХ-ны хадгаламж, зээлийн Г
үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг
хүчингүй болгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10.1.5, Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 48.4, 56.2.5, Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 60 дугаар тогтоолоор батлагдсан “Хадгаламж зээлийн хоршооны зохицуулалтын журам”-ын 9.7.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Чинду” ХЗХ-ны хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосугай.
2. ХЗХ-г татан буулгаж, хадгаламж, зээлийн үлдэгдэл, төлбөр тооцоог барагдуулахыг “Чинду” ХЗХ /С.Чинбат/-нд үүрэг болгосугай.
3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



ДБАЯРСАЙХАН

000372